



## ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЗОХИЦУУЛАХ ХОРОО

Радио давтамжийн хуваарилалт, хууль  
эрхзүй, зохицуулалт

РДЗХГ-ын РДЗХ-ийн Радио  
давтамжийн хуваарилалт,  
бүртгэлийн мэргэжилтэн Б.Батцэцэг

2026/06/26



## Агуулга



РАДИО ДОЛГИОНЫ ТУХАЙ ХУУЛЬ

ЗӨВШӨӨРЛИЙН ТУХАЙ ХУУЛЬ



РАДИО ДАВТАМЖИЙН ЗОХИЦУУЛАЛТ



ШИНЭЧИЛСЭН БАРИМТ БИЧГИЙН  
ТӨСӨЛ



# РАДИО ДОЛГИОНЫ ТУХАЙ ХУУЛЬ

## 1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь радио долгионыг хуваарилах, ашиглах, хамгаалах, өмчлөх, эзэмшихтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

## 5<sup>1</sup> дүгээр зүйл. Харилцаа холбооны зохицуулах хорооны бүрэн эрх

5<sup>1</sup>.1.Харилцаа холбооны зохицуулах хороо радио долгионы талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

5<sup>1</sup>.1.2.Радио давтамж, радио давтамжийн зурвасын хуваарилалт хийх, радио давтамжид баримтлах зохицуулалт, радио төхөөрөмжийн техникийн шаардлага, норматив баримт бичиг батлах, хэрэгжилтэд нь хяналт тавих;

5<sup>1</sup>.1.3.улс орны зайлшгүй хэрэгцээ болон техник, технологийн шинэ дэвшлийг нэвтрүүлэхэд шаардагдах радио давтамжийн зурвасын судалгаа хийх, нөөцийг бүрдүүлэх;

5<sup>1</sup>.1.4.Монгол Улсад радио долгионы хяналтын нэгдсэн тогтолцоог бүрдүүлэх;

5<sup>1</sup>.1.8.хуульд заасан тусгай зөвшөөрөл, эрхийн бичиг, тохирлын гэрчилгээ олгох, хугацааг сунгах, тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох, тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага болон холбогдох журмыг батлах, гэрээ байгуулах, хэрэгжилтэд хяналт тавих;

5<sup>1</sup>.1.9.радио холбооны сүлжээ сарниулах тоног төхөөрөмж ашиглах журам батлах, хяналт тавих

## 8 дугаар зүйл. Радио давтамж, радио давтамжийн зурвас, радио төхөөрөмж ашиглахыг хориглох

8.1.Радио давтамж, радио давтамжийн зурвас ашиглах тусгай зөвшөөрөл, эрхийн бичиггүй этгээд радио давтамж, радио давтамжийн зурвас ашиглахыг хориглоно.

8.2.Хуульд өөрөөр заагаагүй бол иргэн, хуулийн этгээд тохирлын баталгаагүй радио тоног төхөөрөмж ашиглахыг хориглоно.

8.3.Хуульд өөрөөр заагаагүй бол радио холбооны сүлжээ сарниулах тоног төхөөрөмж ашиглах, импортлох, үйлдвэрлэх, худалдахыг хориглоно.



# РАДИО ДОЛГИОНЫ ТУХАЙ ХУУЛЬ

7.1. Нийтийн хэрэглээний радио давтамжийн зурвасыг Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу байгуулагдаж, үйл ажиллагаа явуулж байгаа хуулийн этгээд, иргэн энэ хуулийн дагуу Зохицуулах хорооноос тусгай зөвшөөрөл, эрхийн бичиг авч, бүртгүүлж ашиглана.

9.1. Төрийн эрх бүхий байгууллагаас радио холбоо зохион байгуулах, түүнийг ашиглан үйлчилгээ эрхлэх, **нийтийн үйлчилгээний зориулалтаар** радио төхөөрөмж ажиллуулахын тулд радио давтамж, радио давтамжийн зурвас ашиглах эрх олгосон баримт бичгийг тусгай зөвшөөрөл гэнэ.

13.1. Иргэн, хуулийн этгээд хувийн болон дотоод хэрэглээний харилцаанд зориулан радио холбоо зохион байгуулах, эрдэм шинжилгээ, туршилтын ажиллагаа явуулах бусад бүх төрлийн радио төхөөрөмжийг **нийтийн үйлчилгээний бус зориулалтаар** ашиглахад радио давтамж ашиглах эрхийг баталгаажуулсан баримт бичиг /цаашид “эрхийн бичиг” гэх/ олгоно.





# ЗӨВШӨӨРЛИЙН ТУХАЙ ХУУЛЬ

## Зөвшөөрлийн тухай хуулийн 2.1 дүгээр зүйл. Зөвшөөрлийн ангилал

1. Зөвшөөрлийн тухай хуулийн 2.1 дүгээр зүйлд зөвшөөрлийг түүний зорилго, олгох нөхцөл, үйл ажиллагааны онцлог, эрсдэлийн түвшнээс хамааруулан дараах байдлаар ангилсан.

1.1. тусгай зөвшөөрөл;

1.2. энгийн зөвшөөрөл.

## 8.1 дүгээр зүйл. Тусгай зөвшөөрлийн жагсаалт

9. Харилцаа холбоо, мэдээлэл технологийн чиглэлээр доор дурдсан үйл ажиллагааг тусгай зөвшөөрөлтэйгөөр эрхлэх бөгөөд дараах этгээд олгоно:

Тусгай зөвшөөрөл	Тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий этгээд
9.2-9.15 дахь заалтууд	Харилцаа холбооны зохицуулах хороо

## 8.2 дугаар зүйл. Энгийн зөвшөөрлийн жагсаалт

8. Харилцаа холбоо, мэдээлэл технологийн чиглэлээр доор дурдсан үйл ажиллагааг энгийн зөвшөөрөлтэйгөөр эрхлэх бөгөөд дараах этгээд олгоно:

Энгийн зөвшөөрөл	Энгийн зөвшөөрөл олгох эрх бүхий этгээд
8.3. радио давтамжийг <b>нийтийн үйлчилгээний бус зориулалтаар</b> ашиглах	Харилцаа холбооны зохицуулах хороо



## РАДИО ДАВТАМЖИЙН ЗУРВАСЫН ЗОХИЦУУЛАЛТ

д/д	Давтамжийн зурвас (МГц)	Ашиглах технологи	Хуваарилах сувгийн өргөн (кГц)
1	138-139.6	Аналоги / Тоон	Тоон - 6.25 / 12.5  Аналоги - 25
2	146-148		
3	150.5-151		
4	152.4-153.1		
5	155-156.5625		
6	158-160		
7	161-163		
8	167.1-169		
9	170-171		
10	230-250	Тоон	6.25 / 12.5
11	267-290		
12	300-320		
13	370-380		
14	401-406	Аналоги / Тоон	Тоон - 6.25 / 12.5  Аналоги - 25
15	410-416		
16	420-427		
17	430-442		
18	443.5-447		
19	448.5-452		
20	458-462		
21	469-470		

ХХЗХ-ны 2023 оны 73 тоот тогтоолын хавсралтаар батлагдсан “Харилцааны радио станцад ашиглах радио давтамжийн зурвасын хуваарилалт, техникийн нөхцөл, шаардлага”-ын нэгдүгээр хавсралт дахь давтамжийн зурвасыг ашиглах ба сувгийг аналого болон тоон технологиор хуваарилдаг.



Уул уурхай



Харуул хамгаалалт



Үйлдвэрлэл



Барилга угсралт




Бусад



# ЭРХИЙН БИЧИГ ШИНЭЭР АВАХАД:

## № Радио давтамж ашиглах эрхийн бичгийг шинээр авахад бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт:

1. Албан бичиг
2. Радио давтамж, радио давтамжийн зурвас ашиглах эрхийн бичиг хүсэх өргөдлийн маягт
3. Доорх хавсралтын аль нэгийг  
Хавсралт 1: Харилцааны радио станц  
Хавсралт 2: Радио линкний станц  
Хавсралт 3: Өгөгдөл дамжуулах станц  
Хавсралт 4: Сансрын холбооны станц  
Хавсралт 5: Хөдөлгөөнт холбооны станц  
Хавсралт 6: Сонирхогчийн станц  
Хавсралт 7: Бусад төрлийн станц
4. Ашиглах радио тоног төхөөрөмжийн нэвтрүүлэгчийн болон антены техникийн үзүүлэлт хавсаргах
5. Тоног төхөөрөмжийн баталгаажуулалтын талаарх мэдээллийг хавсаргах
6. Тоног төхөөрөмжийн ажиллагааны зарчим болон радио холбооны сүлжээ зохион байгуулах зургийг хавсаргах
7. Станцын хамрах хүрээний зураглалыг хавсаргах



<https://crc.gov.mn/> сайт руу орж бүрдүүлэх материал болон бүрдүүлэх материал, бөглөн ирүүлэх маягтыг татаж авах боломжтой




ХАРИЛЦАА ХОЛБООНЫ  
ЗОХИЦУУЛАХ  
ХОРОО

# ЦАХИМ СИСТЕМЭЭР ЭРХИЙН БИЧИГ ШИНЭЭР АВАХАД:

Тус хороо нь зөвшөөрлийн хүсэлт шийдвэрлэх ажиллагааг цахимжуулах ажлыг үе шаттайгаар нэвтрүүлж байгаа бөгөөд зөвшөөрөлд шинэ, сунгалт, өөрчлөлт хийх хүсэлтийг тус хорооны цахим хуудсаар хүлээн авч байна. Байгууллага нь тоон гарын үсэгтэй бол <https://customer.crc.gov.mn/> цахимаар сунгах хүсэлтэй гаргана уу.

## Тоон гарын үсгийг хаанаас авах вэ?

- <https://tridumkey.mn/>
- <https://burtgel.gov.mn/g-sign>
- Хурдан киоск машин





# Радио давтамж ашиглах эрхийн бичиг авахад бүрдүүлэх өргөдлийн маягтыг бөглөх заавар

Радио долгионы тухай хуулийн 13 зүйлийн дагуу иргэн, хуулийн этгээд хувийн болон дотоод хэрэглээний харилцаанд зориулан радио холбоо зохион байгуулах, эрдэм шинжилгээ, туршилтын ажиллагаа явуулах бусад бүх төрлийн радио төхөөрөмжийг нийтийн үйлчилгээний бус зориулалтаар радио давтамж, радио давтамжийн зурвас ашиглах эрхийн бичиг авахдаа энэхүү өргөдлийн маягтыг бөглөн ирүүлнэ.

Үүнд:

- Хөдөлгөөнт станц,
- Суурин станц,
- Дахин дамжуулагч станц



ХАВСРАЛТ 1: ХАРИЛЦААНЫ СТАНЦ / WALKIE TALKIE			
<b>Санамж:</b>			
<ul style="list-style-type: none"> <li>Хөдөлгөөнт станц гэдэг нь хөдөлгөөнт байдлаар ашиглагдах харилцааны гар станц болон машины станцыг хэлнэ.</li> <li>Суурин станц гэдэг нь хөдөлгөөн бус байдлаар ашиглах харилцааны гар станц, машины станц болон дахин дамжуулах станцуудыг хэлнэ. Иймд та аль төрлийн станцыг ашиглахаас хамарч тухайн станцын мэдээлэл хэсэгт төхөөрөмжийн мэдээллийг бөглөнө үү.</li> </ul>			
<b>1. ХӨДӨЛГӨӨНТ СТАНЦЫН МЭДЭЭЛЭЛ</b>			
1.1. Хөдөлгөөнт станцыг ашиглах хамрах хүрээ			
Хот, дүүрэг, сум, хамрах хүрээ, маршрут, ажиллах газрын нэр / City, province, area of coverage			
Метро бизнес төв, А корпус, 5-р давхар Д.Сүхбаатарын гудамж-13 Сүхбаатар дүүрэг УБ 14201-0033			
1.2. Хөдөлгөөнт станцын техникийн үзүүлэлт / Mobile station details			
Станцын төрөл / Station type	Төхөөрөмж үйлдвэрлэгчийн нэр, загвар / Manufacturer, model	Тоо ширхэг / Quantity	
<input type="checkbox"/> Гар станц	Motorola M-1	10	
<input type="checkbox"/> Машины станц			
Гаралтын чадал (Вт) / Power (W)	Үйлчлэх хүрээ (м) / Radius of service (m)		
<input checked="" type="checkbox"/> Гар станц:	5 Вт	5 км	
<input type="checkbox"/> Машины станц:			
Нэвтрүүлэх технологи / Transmitting technology	Ажиллах боломжтой давтамжийн зурвас (МГц) / Available frequency band (MHz)	Зурвасын өргөн (МГц) / Frequency bandwidth (MHz)	
<input checked="" type="checkbox"/> Аналог / analogue	136-174 МГц	<input type="checkbox"/> 6.5 кГц	
<input type="checkbox"/> Тоон / digital		<input type="checkbox"/> 12.5 кГц	
		<input checked="" type="checkbox"/> 25 кГц	
		400-470 МГц	
<b>2. СУУРИН СТАНЦЫН МЭДЭЭЛЭЛ / DEVICE INFORMATION OF FIXED STATION</b>			
2.1 Суурин станцын хаяг, байршил / Location of fixed station			
Хот / Аймаг,   City / province	Сум, дүүрэг, хороо, хороолол / Area, district	Байрны нэр, дугаар / Apartment building number	
Улаанбаатар хот 14201-0033	Д.Сүхбаатарын гудамж-13, Сүхбаатар дүүрэг	Метро бизнес төв, А корпус, 5-р давхар	
Уртраг / Longitude / E		Өргөрөг / Latitude / N	
Радио нэвтрүүлэгч станцын байршлын мэдээллийг Google Earth програм ашиглан координатыг "decimal degrees" /DDD.DDDDD/ форматаар үнэн зөв бөглөнө.		106.550531	
Төхөөрөмж үйлдвэрлэгчийн загвар, нэршил / Manufacturer, model	Тоо ширхэг / Quantity	Чадал (Вт) / Power (W)	
Kenwood TM471A	10	25 Вт	
Нэвтрүүлэх технологи / Transmitting technology	Ажиллах боломжтой давтамжийн зурвас (МГц) / Available frequency band (MHz)	Ашиглах зурвасын өргөн (МГц) / Bandwidth (MHz)	
<input checked="" type="checkbox"/> Аналог / analogue	136-174 МГц	<input type="checkbox"/> 6.5 кГц	
<input type="checkbox"/> Тоон / digital		<input type="checkbox"/> 12.5 кГц	
		<input checked="" type="checkbox"/> 25 кГц	
		400-470 МГц	

2.2. Суурин станцын антены үзүүлэлт / Antenna details for fixed station			
Антены үйлдвэрлэгч, загвар / Manufacturer, Model	Тоо ширхэг / Quantity	Өсгөлтийн коэффициент (дБ) / Gain (dB)	Цацаргалтын төрөл / Class of emission
Diamond BC-200L	1	6.5dBi	Omnidirectional
Антены ажиллах давтамж (МГц) / antenna frequency range (MHz)	Антены төрөл / Antenna type	Антены өндөр (м) /Antenna height (m)	Антены далайн түвшнээс дээш өндөр (м) /Antenna height above sea level (m)
	2x5/8 λ коллинеар босоо антены	1.7 m	
400-470 МГц			
136-174 МГц			
<b>3. ДАХИН ДАМЖУУЛАХ СТАНЦЫН МЭДЭЭЛЭЛ / DEVICE INFORMATION OF REPEATER</b>			
3.1 Дахин дамжуулах станцын байршил / Address of repeater			
Хот / Аймаг,   City / province	Сум, дүүрэг, хороо, хороолол / Area, district	Байрны нэр, дугаар / Apartment building number	
Уртраг / Longitude / E		Өргөрөг / Latitude / N	
3.2 Дахин дамжуулах станцын үзүүлэлт / Repeater station details			
Төхөөрөмж үйлдвэрлэгч, загвар / Manufacturer, model	Тоо ширхэг / Quantity	Чадал (Вт) / Power (W)	
Нэвтрүүлэх технологи / Transmitting technology	Ажиллах боломжтой давтамжийн зурвас (МГц) / Available frequency band (MHz)	Зурвасын өргөн (МГц) / Frequency bandwidth (MHz)	
<input type="checkbox"/> Аналог / analogue		<input type="checkbox"/> 6.5 кГц	
<input type="checkbox"/> Тоон / digital		<input type="checkbox"/> 12.5 кГц	
		<input type="checkbox"/> 25 кГц	
Үйлчлэх хүрээ (км) / Radius of service (km)	Газрын түвшнээс дээших өндөр (м) / Height above ground level (m)		
3.3. Дахин дамжуулах станцын антены үзүүлэлт / Repeater antenna details			
Антены үйлдвэрлэгч, загвар / Manufacturer, model	Тоо ширхэг / Quantity	Өсгөлтийн коэффициент (дБ) / Gain (dB)	Цацаргалтын төрөл / Class of emission
Антены төрөл / Antenna type	Антены ажиллах давтамж / antenna frequency range	Антены өндөр (м) /Antenna height (m)	Антены далайн түвшнээс дээш өндөр (м) /Antenna height above sea level (m)



# РАДИО ДАВТАМЖИЙН ЗУРВАСЫН ТӨЛБӨРИЙН ХЭМЖЭЭ

## ХОЁР. РАДИО ДАВТАМЖ АШИГЛАХ ЭРХИЙН БИЧГИЙН ТӨЛБӨРИЙН ХЭМЖЭЭ

### 2.1 ХАРИЛЦААНЫ РАДИО СТАНЦ

#### 2.1.1 Радио давтамжийн зурвас ашиглалтын төлбөр

F:	$F_{bw} \leq 12$ кГц	$F_{bw}: 12-36$ кГц	$F_{bw}: 36-100$ кГц	$F_{bw}: 100$ кГц-ээс их үед 100 кГц тутамд
$F_r: 3-30$ МГц	12 000	24 000	30 000	24 000
$F_r: 30-300$ МГц	35 000	45 000	50 000	30 000
$F_r: 300-1\,000$ МГц	35 000	45 000	50 000	30 000

#### 2.1.2 Радио нэвтрүүлэгчийн гаралтын чадлын төлбөр

P:	$F_r: 3-30$ МГц	$F_r: 30-1\,000$ МГц
$P_H: \leq 1$ Вт хүртэл	15 000	15 000
$P_H: 1 - 5$ Вт	20 000	20 000
$P_H: 5 - 10$ Вт	30 000	30 000
$P_H: 10 - 25$ Вт	35 000	40 000
$P_H: 25 - 50$ Вт	45 000	50 000
$P_H: 50 - 100$ Вт	60 000	70 000
$P_H: 100 - 500$ Вт	80 000	100 000
$P_H: 500 - 1$ кВт	100 000	200 000
$P_H: 1$ кВт-аас дээшхи бүрэн ба бүрэн бус 1 кВт тутамд	50 000	50 000

#### 2.1.3 Төрөл ангилал / хамрах хүрээний төлбөр


T:	Аналоги	Тоон
Суурин, дахин дамжуулах болон хөдөлгөөнт станцын нэвтрүүлэгчийн чадал, $P \leq 5$ Вт станц тутамд	10 000	5 000
Суурин, дахин дамжуулах болон хөдөлгөөнт станцын нэвтрүүлэгчийн чадал, $P > 5$ Вт станц тутамд	20 000	10 000

ХХЗХ-ны 2023 оны 94 тоот тогтоолын хавсралтаар батлагдсан “Радио давтамжийн ашиглалт, үйлчилгээний төлбөрийн хэмжээ”-г иргэн, хуулийн этгээдэд зөвшөөрлөөр олгосон радио давтамжийн ашиглалт, үйлчилгээний төлбөрийн хэмжээг тогтооно.

№	Өгөгдөл	Оногдох төлбөр	Төлбөр
З	Радио давтамжийн 1 суваг	45 000₮ x 1с	45 000₮
P	Гар станц = 5 ширхэг, 5 Вт	20 000₮ x 5ш	100 000₮
Y	5 Вт-аас доош /аналоги/	10 000₮ x 5ш	50 000₮
T	<b>Радио давтамж ашиглалтын 1 жилийн төлбөр</b>		<b>195 000₮</b>



## 2022-2026.06.25-ны өдрийг хүртэлх эрхийн бичгийн зөвшөөрлийн мэдээлэл



	Шинэ хүсэлт	Сунгалт	Өөрчлөлт	Хүчингүй болгох
■ 2022 он	174	170	17	6
■ 2023 он	153	78	27	7
■ 2024 он	158	136	124	16
■ 2025 он	166	37	31	15
■ 2026.06.25 хүртэл	51	74	11	16



## ШИНЭЧИЛСЭН БАРИМТ БИЧГИЙН ТӨСӨЛ



Шинэчилсэн баримт бичгийн төслийг харилцаа холбооны зохицуулах хорооны [www.crc.gov.mn](http://www.crc.gov.mn) цахим хуудсанд 2026 оны 05-р сарын 12-ны өдрөөс 2026 оны 06-р сарын 12-ны өдөр хүртэл 30 хоногийн хугацаанд санал авахаар нийтийн хэлэлцүүлэгт байршуулсан.

Эрх нь зөрчигдөж болзошгүй үйлчилгээ эрхлэгч байгууллагад албан бичгээр санал авах тухай Цахим хөгжил, инноваци харилцаа холбооны яам 2026.05.27 01/1050  
Иргэний нисэхийн үндэсний төв төххк 2026.05.18 04/1000

Тогтоол	Радио давтамжийн зурвасын хуваарилалтын баримт бичиг	Байгууллагуудаас ирүүлсэн санал
2023 оны 07 дүгээр сарын 04-ний өдрийн 72 дугаар тогтоол	Радио релейнд ашиглах радио давтамжийн зурвасын хуваарилалт, техникийн нөхцөл шаардлага	ЦХИХХЯам Ондо ХХК Опенвэйкс ХХК
2023 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 73 дугаар тогтоол	Харилцааны радио станцад ашиглах радио давтамжийн зурвасын хуваарилалт, техникийн нөхцөл шаардлага	Радио станцад ашиглах сувгийг 29-өөр нэмэгдүүлж, Сонирхогч:Цаг уур шинжлэл: тус тус нэмж тусгасан. ЦХИХХЯ
2021 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн 63 дугаар тогтоол	Иргэний нисэхийн агаарын холбооны үйлчилгээнд ашиглах радио давтамжийн зурвасын хуваарилалт, техникийн нөхцөл, шаардлага	нөхцөл, шаардлага – 10 хассан (хяналт, хариуцлага-9) Радио давтамжийн зурвас – 336.8 МГц хассан (300 МГц – ҮРДХХ, ТХ-нд) Стандарт – 2 хассан ЦХИХХЯ ИНҮТ ТӨХХК



ХАРИЛЦАА ХОЛБООНЫ  
ЗОХИЦУУЛАХ  
ХОРОО

АНХААРАЛ  
ХАНДУУЛСАНД  
БАЯРЛАЛАА